

ӨДӨР ТУТМЫН СОНИНУУД БОЛОВСРОЛЫН СЭДВИЙГ ХӨНДӨЖ
БУЙ АСУУДАЛД

Б.Наранбаатар*, У.Түвшинбаяр**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Өдөр тутмын сонин, сэтгүүл зүй, боловсрол, сэтгүүл зүй үүрэг, мэдээллийн эрэлт, хэрэгцээ, уншигч, мэдээллийн багтаамж, ач холбогдол

Мэдээллийн технологи, интернет, мэдээлэл хүртэх боломжит хэрэгслүүдийн хөгжлийн нөлөөгөөр сонины зах зээл хумигдаж, мэдээллийн хоцрогдол нь улам бүр шийдвэрлэхэд төвөгтэй асуудал болж буй. Сонин нь өнөөдөр болсон мэдээллийг маргааш түгээдэг бол сайт нь хэдхэн минутын ард нийтэлдэг гэдгийг бид мэднэ. Гэвч тухайн мэдээллийг шалгах, нягтлах, илүү олон эх сурвалжаар баталгаажуулах цаг хугацаа өдөр тутмын сонины сэтгүүлчдэд бий. Мөн улс төр, нийгэм, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, экологи зэрэг сэдвийн хүрээнд нийгэмд тулгамдаж буй асуудлыг шийдэх зорилгоор баримт нотолгоотойгоор гаргаж ирэн, дахин давтагдашгүй бүтээл туурвин уншигчийн сонирхлыг татах боломж өдөр тутмын сонины зах зээлд байсаар байна. Манай Улсын хувьд, уул уурхайн хөрөнгө оруулалт ярьж, эдийн засгийн салбарыг нэгдүгээрт гэж үздэг. Харин дараа нь сонгууль, улс төрд анхаарлаа хандуулан, боловсрол, эрүүл мэнд зэрэг чухал салбарт тулгамдаж буй

асуудлыг орхин, эсвэл өнгөц авч үзэн, хөнгөнөөр томъёолдог. Жишээлбэл, боловсролын салбарын хувьд ЕБС-ийн сургалтын шинэчлэл, чанаргүй их дээд сургуулийн тоо, нэгдүгээр ангийн хүүхдийн цүнхний жин, сурах бичгийн хэмжээ, их дээд сургууль төгсөгчдийн ажлын байр, ур чадвар гэх мэт тоо томшгүй асуудал бий. Гэтэл манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд жил бүрийн зургаадугаар сард ЭЕШ, их дээд сургуульд элсэх, бүртгэл, наймдугаар сард хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил, сургуулийн барилгын засвар, хичээлийн хэрэглэгдэхүүний үнэ ханш зэрэг төдийхнөөр боловсролын салбарын асуудлыг гарган бичиж байна. “Сэтгүүл зүйн үүргийг нийгмийн амьдралын онцлог, түүнд оролцох боломжийн илрэлийн үүднээс авч үзэх нь үүргийг янз бүрийн төвшинд авч үзэх боломж өгдөг. Өөрөөр хэлбэл, нийгмийн давхаргын институт, улс төрийн системийн элемент, мэдээллийн хэрэгсэл болох онцлогийг харгалзах нь сэтгүүл зүйн үүргийн дотоод элемент, бүтцийг бүрэн гаргахад чухал ач холбогдолтой юм. Тэгвэл ОНМХ мэдээлэх, олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх, хяналтын, харилцааны, танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх, зугаацуулах үүргийг биелүүлдэг гэж хэлж болно”¹.

Боловсролын яамны албан мэдээ болон томилолт, хурал форум зэргийг цаг тухайд нийтэлж нэвтрүүлдэг. Өөрөөр хэлбэл, боловсролын салбарын асуудлууд нь цаг үеийн сэдэв болж, зөвхөн зуны саруудад л энд тэндхийн хэлний сургалт, сургуулийн барилгын асуудал зэргээр хязгаарладаг. Үүнээс үзэхэд, манайд боловсролын салбарын тухай авч үзэхдээ, хүнийг нь орхиод, эд юмсын хүрээнд зааглаж байна. Гэтэл хувь хүний боловсрол бүхий л зүйлд шаардагддаг. Тухайлбал, сонгуульд оролцохын тулд иргэдийн улс төрийн боловсрол, байгаль дэлхийтэйгээ зөв харьцахын тулд экологийн боловсрол, өвчингүй байхын тулд эрүүл мэндийн боловсрол гэх мэт. Хувь хүний боловсрол зөвхөн тухайн хүний бус, нийт улс үндэстний хэмжээнд тавигдаж байгаа боловсролын бодлоготой яах аргагүй холбоотой. Тиймээс ч аливаа улс орны төр засаг иргэдийнхээ боловсролыг дэмжих үүрэг хүлээж, боловсролын үр өгөөж нь хувь хүн бүр дээр илэрч байх учиртай. Жишээлбэл, социализмын үед манай төр засгийн зүгээс бүх нийтээрээ бичиг үсэгтэн болохын тулд боловсролын салбартаа хамгийн их хөрөнгө оруулалт хийж байсан тухай Юнескогийн Засгийн газрын зардлын статистик эмхэтгэлд дурдсан байдаг.

Бид “Өнөөдөр” сонин, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинуудын боловсролын сэдвээр бичигдсэн нийтлэлүүдэд контент судалгааны аргыг ашиглан анализ хийв.

“Өнөөдөр”² сонины тэргүүн нүүрэнд хөтөч материалууд болон шаардлагатай цаг үеийн мэдээнүүд эзэлжээ. Харин А2 нүүрт улс төрийн сэдэвт нийтлэлүүд тогтмол байршиж байв. Мөн А3 нүүрт тоймчийн үг болон нийгэм тулгамдаж буй асуудлыг хөндүүр сэдэв гэх булангаар тогтмол

нийтэлдэг. А4, А5 нүүрт сурталчилгаа, А6 нүүрт түүхэн хүний талаарх хөрөг болон ярилцлагууд багтжээ. А7 нүүрт сурталчилгаа, А8 нүүрт гадаад мэдээнүүдийг “Ертөнц”, “Дэлхий” гэх буланд тогтмол нийтэлсэн байна. В1 нүүрт цаг үе, үйл явдлын мэдээнүүд, В2 нүүрт хүмүүсийн аж амьдралын тухай ярилцлага, В3 нүүрт аялал жуулчлал болон эдийн засаг, В4 нүүрт сурталчилгаа танин мэдэхүй, В5 нүүрт эдийн засаг, В6 нүүрт спорт, В7 нүүрт экологи, уран зохиол, В8 нүүрт сонирхолтой баримт, мэдээнүүд гэх зэргээр нийтэлжээ. Харин боловсролын асуудлын тухай мэдээ, ярилцлага, сурвалжилга зэргийг нийтэлдэг тогтмол нүүр, булан гэж байхгүй байна. Цаг үеийн хувьд, боловсролын асуудлыг хөндсөн нийтлэлүүд зургаадугаар сарын дунд үе, наймдугаар сарын сүүлийн долоо хоногт В2 болон А3 нүүрт нийтлэгдсэн байна. Боловсролын сэдэвт нийтлэлийн хувьд, цаг үе, үйл явдлын мэдээ цөөн. Харин асуудал дэвшүүлсэн сурвалжилга, нийгэмд тулгамдаж буй асуудлаар албаны хүнээс авсан тодруулга, ярилцлага зэрэг тодорхой хэмжээгээр байна. Хэдий хангалттай хэмжээтэй биш ч тухайн нийтлэлүүд дотор мэдээллийн багтаамж маш сайтай, асуудлыг ил тодоор шүүмжилсэн, засаж залруулах арга замыг гаргаж өгсөн нийтлэл байна.

“Өдрийн сонин”³ нь тогтмол 16-20 нүүрээр, зарим тохиолдолд 16-24 хүртэлх нүүрээр хэвлэгддэг. Тус сонинд улс төрийн сэдвийн хүрээн дэх асуудлыг чухалчилдаг болох нь илт ажиглагдав. Тухайлбал, 2-р нүүр улс төр, 3-р нүүр баримт, үзэл бодол, 4 болон 5-р нүүр мөн улс төрийн шинжтэй мэдээ материал, 7-р нүүр үйл явдал, баримт, 8-р нүүр цаг үе, 9-р нүүр дэлхийн мэдээ,

10-р нүүр сурталчилгаа, 11-р нүүр эдийн засаг, 12-р нүүр танайд өнжье, хүмүүсийн тухай, 13-р нүүр баяр ёслол, 14-р нүүр сурталчилгаа, 15-р нүүр цаг үе, үйл явдал, 16 нүүр зар сурталчилгаа, 17-р нүүр сонин хачин, 18-р нүүр зар сурталчилгаа, 19-р нүүр цаг үе, залуус, 20-р нүүр энэ өдөр буюу зурхай, цаг агаар зэрэг сэдэв эзэлж байна. Үүнээс үзэхэд улс төрийн асуудал болон, гадаад мэдээ, зар сурталчилгаа зэрэг нь бусад сэдвээс илүү олон хуудсанд бичигджээ. Боловсролын талаарх мэдээллийг тус сонин нь “Багш”, “Нэг ангийнхан” зэрэг булангаар нийтэлдэг. Улс төрийн булантай ижил, төрөлжсөн, тогтмол булан байхгүй. ЭЕШ, хичээл сургуулийн бэлтгэл ажил, энд тэнд зохиогдох форум, их дээд сургуулийн төлбөр гэх сэдвийн хүрээнд байна. Харин “Багш” булангаараа тухайн нэг багшийн түүх, хичээлээ заадаг арга барил зэргийг харуулдаг.

“Зууны мэдээ”⁴ сонин нь 8-16 нүүрээр хэвлэгддэг. Үүнээс 8 нүүр нь тогтмол юм. 1-р нүүрт-хөтөч материалууд, 2-р нүүрт улс төр, 3-р нүүрт цаг үе, баримт тайлбар, 4-р нүүрт мөн цаг үеийн мэдээллүүд, 5-р нүүрт эдийн засаг, уул уурхай, 6-р нүүрт сурталчилгаа, 7-р нүүрт боловсрол, бөхийн мэдээ, эрүүл мэнд, өөр мэдээ, спорт, амьдралын тойрог, 8-р нүүрт энтертайнмент зэрэг сэдвийн мэдээ, нийтлэлүүд эзэлж байна. Үүнээс 7-р нүүрийг авч үзвэл, тус нүүрт долоон сэдэв багтаж байгааг ажиглалаа. Өөрөөр хэлбэл бусад сэдэв дангаараа нэг нүүрийг байнгын дүүргэж байна. Харин 7-р нүүрийн сэдвүүд 7 хоногийн зайтай солигдож байна. (8 нүүр 100 хувь, 1 нүүр 12.5 хувь, 7-р нүүрт 7 сэдэв байна. Тэгэхээр 7 сэдэв 12.5 хувь, нэг сэдэв нь 1.7 хувь) Үүнээс харахад, тус

сонинд нэг долоо хоногийн хугацаанд нийтлэгдэж буй бүх сэдэвтэй харьцуулж үзэхэд дунджаар 1.7 хувь тусгаж байна. “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонинтой харьцуулахад, боловсролын сэдвээр бичсэн мэдээллийг оруулдаг тодорхой булантай нь давуу юм. Харин “Боловсрол мэдээ” гэх булан нь сард 1-2 удаа л гаргадаг. Тус буланд нь ихэвчлэн сургууль, цэцэрлэгийн ашиглалтад орох хугацаа, үйл явдал цаг үеийн товч мэдээ, сургууль цэцэрлэгийн хүрэлцээ зэрэг асуудлыг авч үзжээ. Нийтлэлийн агуулгын хувьд, мэдээллийн багтаамж муутай, тоо баримт ховор, голдуу сэтгүүлчийн үзэл бодлоор бичигддэг болох нь харагдлаа. Монголд үйл ажиллагаа явуулж буй өдөр тутмын есөн сонин байна.

“Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”-д нийтэлсэн боловсролын сэдэвт нийтлэлийн гарчиг, тухайн сэдвээр нэг сэтгүүлч дагнан бичиж байгаа эсэх, гол асуудал, хөндөж буй сэдэв, байршуулж буй булан, нийтэлж буй нүүр зэргийг судалж бичлээ. Ингэхдээ тус сонинуудын 2019 оны зургаа, долоо, наймдугаар сарын сонгон түүвэрлэв. “Өнөөдөр” сонинд боловсролын сэдэвтэй 42 нийтлэл байна. Үүнд, мэдээ- 23, сурвалжилга-9, ярилцлага-10 байна. Зургаадугаар сарын гурав дахь долоо хоног, мөн наймдугаар сарын гурав дахь долоо хоног зэрэг боловсролын асуудлыг хөндсөн нийтлэлийн тоо бусад долоо хоногуудаас илүү байна. Энэ нь тухайн цаг үед ЭЕШ, хичээлийн шинэ жилтэй холбоотой асуудлууд нийгмийн сэдэв болдог. Харин сарын хугацаагаар авч үзвэл, наймдугаар сард илүү байна. Долоодугаар сард бага байгаа нь улсын их баяр наадам болж, бүх нийтийн амралт ихэсдэгтэй холбоотой. Хэмжээний хувьд, сонины нэг нүүрийг 8 гэж үзэн, 1/8, 2/8, 3/8, 4/8,

5/8, 6/8, 7/8, 8/8 буюу нэг нүүр гэх мэтчилэн ангилсан. Үүнээс үзэхэд, Өнөөдөр сонинд 2/8, 5/8, 6/8, 7/8 гэсэн хэмжээнүүдээр бичигдсэн материал байхгүй байна. 8/8 буюу бүтэн нэг нүүрээр ярилцлага, сурвалжилга, харин 1/8 хэмжээтэй жижиг мэдээ 23, 3/8, 4/8 дундын хэмжээтэй ярилцлага, сурвалжилга байна. Эхний нүүрэнд зургаан мэдээ, харин цаг үеийн сэдэв зонхилдог В1 нүүрэнд 11 мэдээ байна. Өнөөдөр сонин нь цаг үеийн асуудлыг чухалчилдаг болох нь харагдаж байна. АЗ нүүр нь маш чухал сэдвийг хөндөж бичдэг нүүр бөгөөд гурван сарын хугацаанд тус нүүрт боловсролын талаар 2 сурвалжилга, нэг тодруулга байна. Энэ нь маш чамлалттай санагдав. Булан нь ихэвчлэн тогтмол байдаг. Гэхдээ цаг үеийн байдлаас шалтгаалан өөрчлөгдөх үе бий. Тиймээс тогтмол булангуудыг үүнд авч үзлээ. Цаг үе буланд хамгийн их буюу 10 нийтлэл байна. Тиймээс боловсролын асуудлаарх цаг үеийн асуудлыг ихэвчлэн бичдэг. Бичлэгийн төрөл зүйлийн хувьд цаг үе буланд ихэвчлэн мэдээ байршдаг.

Олимпиад уралдаан, тэтгэлэгт хөтөлбөрүүд, болон ЕБС-ийн асуудлууд хамгийн их байна. Маш чухал хөндсөн асуудлыг хөндсөн нийтлэлийн онцолбол, хөндүүр сэдэв буланд байгаа. Гарчиг эх бичвэрийн талаар товч мэдээлэл өгөх, уншигчийн сонирхлыг өөртөө татах, “хөтөч” болох, материалыг ач холбогдлын дарааллаар хуваарилах, сонин, сэтгүүлийн нүүрийг чимэглэх үүргийг гүйцэтгэдэг. Гарчгийг зорилгын хувьд нэрлэн мэдээлэх гарчиг, зааварлан өдөх, уриалан өдөх, хандан өдөх, мэтгэлцэн өдөх, гоо зүй, сурталчилгааны гарчиг зэргээр ангилдаг. Нэрлэн мэдээлэх гарчиг хамгийн их байна. Харин зааварлан өдөх гарчиг байхгүй. Сурталчилгааны материалуудын

гарчиг нь сурталчилгааны хэв шинжийг агуулсан байна. “Өдрийн сонин”-ы 2019 оны зургаадугаар, долоодугаар, наймдугаар сард боловсролын асуудлын талаар нийт 35 нийтлэл байна. Үүнд: мэдээ-6, сурвалжилга-7, ярилцлага-20 тодруулга-2 байна. Үүнээс үзэхэд, зургаадугаар сарын эхний хоёр долоо хоногт боловсролын сэдэвт нийтлэлийн тоо хамгийн их байна. Энэ нь хичээл сургууль амарсантай холбогдуулж, сургалтын газар, тэтгэлгүүдийн тухай материал элбэг байгааг харуулж байна. Нэг сарын хугацаанд авч үзсэн ч зургаадугаар сарын хамгийн их байна. Энэ нь гадаад хэлний сургалтын төвүүдийн тухай мэдээлэл их гарч байгаатай холбоотой. Өдрийн сонинд боловсролын сэдэвт нийтлэл нь ихэвчлэн нэг нүүрээр гарч байна. Үйл явдлын мэдээ маш бага байна. Мөн бүтэн нүүрийн тал буюу ½ хэмжээний нийтлэлийн тоо ч их байна. Үүний дийлэнх хувийг ярилцлага эзэлж байна.

“Өдрийн сонин” нь 16-20 нүүрээр тогтмол гардаг. Сонины маш чухал материалууд 3,5,7 гэх зэргийн нүүрт байрладаг. Харин хэрэгцээт чанараараа бага материалуудыг 15-р, 16-р гэх зэрэг арын нүүрт байрлуулдаг байна. Боловсролын салбарын асуудлыг 11-р нүүр болон 15-р нүүрт илүү их тусган бичжээ. Сонины хувьд, хамгийн чухал материалыг хамгийн эхэнд байршуулдаг. Харин боловсролын салбарын асуудлыг хойд хэсгийн нүүрүүдэд байрлуулж байгаа нь чухал тооцохгүй байна гэж үзэх үндэслэлтэй юм. “Өдрийн сонин” нь боловсролын байгууллагад олон жилийн турш ажилласан багш нарын ажил, амьдралын туршлагын тухай ярилцлага авч “Багш” буланд нийтэлдэг. Энэ утгаараа боловсролын салбарын асуудлын

талаар 8 нийтлэл байна. “Боловсрол” гэх буланд 5 нийтлэл байна. Эдгээр нийтлэлүүд нь барилгын асуудлыг ихэвчлэн онцолжээ. Боловсролын салбарын асуудал нь дээрх сэдвийн хүрээнд хязгаарлагдаж, харгалзах нүдэнд байгаа асуудлууд нь хөндөгдсөн байна. Хамгийн их давтагдаж буй сэдвүүдийг нь багцлав. “Өнөөдөр” сонины адилаар мөн нэрлэн мэдээлсэн гарчиг хамгийн их байна. Энэ нь сэтгүүл зүйн мэдээлэх үүргээ биелүүлдэг болохыг илтгэж байна. Мөн албаны гурван материалын гарчиг нь сурталчилгааны хэв шинжтэй байна. Зууны мэдээ сонинд боловсролын асуудлыг хөндсөн 60 нийтлэл байна. Үүнд: Мэдээ-37, Сурвалжилга-12, Ярилцлага-9, Тодруулга-2 байна. Өнөөдөр сонины адилаар зургаадугаар сарын гурав дахь долоо хоног боловсролын салбарын асуудлыг түлхүү бичжээ. Энэ хоёр сонины ижил цаг хугацаанд ийнхүү бичиж байгаа нь тухай нэг сэдвээр дагнан бичсэн сэтгүүлчийн хөдөлмөр биш гэдгийг харуулж байна. Нийгмийн нийтлэг цаг үеийн сэдвийн хүрээнд л авч үзжээ.

Наймдугаар сарын сүүлээр хичээл сургууль ордог учир хамгийн их боловсролын асуудлаар бичих хэрэгтэй. Гэтэл хамгийн бага байна. Үүнээс харахад, товч мэдээ хамгийн их байна. Харин бүтэн нүүр материал маш бага байна. Харин ½ хэмжээтэй материал 17 байгаа нь боловсролын салбарын нийтлэлийг чухал тооцож байгааг харуулж байна. Зууны мэдээ сонины 7-р нүүрт боловсролын сэдэвт нийтлэл байдаг. 7-р нүүрт 24 мэдээ байна. Харин сурвалжилга, ярилцлага тус бүр 5 байна. Тодруулгын хувьд, ганц л байгаа чамлалттай байна. ЭЕШ-ын тов, Боловсролын байгууллагын төв, цэцэрлэгийн хүрэлцээ, сувиллын цэцэрлэг,

барилгын хүртээмж шинэчлэл, ЕБС-ийн анги дүүргэлт, гурван ээлжээр хичээллэх, хогийн цэгийн хүүхдүүд, барилгын асуудал, хүүхдийн цахим ертөнц хүүхдэд нөлөөлнө, МСҮТ-ийн нэрэмжит тэтгэлэг зэрэг байна. Нэрлэн мэдээлсэн гарчиг 37 байна. Мэдээ болон сурвалжилгын ихэнх хэсэг нь нэрлэн мэдээлсэн гарчиг байна. Харин боловсролын байгууллагад хандсан гарчиг 8 байна. Манай улсын боловсролын салбар нь гаднын улсаас сургалтын хөтөлбөрүүдийг хуулбарлаж, оруулж ирдэг учраас бүх шатны сургууль, цэцэрлэг, болон сургалтын чанар, хөтөлбөрийн хэрэгжилт гэх мэтээр тухайн салбарт дундаршгүй их асуудал бий. Харин энэхүү асуудлыг сэтгүүлчид, тэр дундаа өдөр тутмын сонины сэтгүүлчид тал бүрээс нь харан, засаж сайжруулахыг тулд бичих нь нийгэмд чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн байдлаар өдөр тутмын сонинд боловсролыг асуудлын талаар тусгахдаа дараах байдлаар хандаж байна. Бидний тоон судалгаа хийсэн гурван сонинд улс төр, эдийн засаг, нийгэм, эрэн сурвалжлах урлаг соёл зэргээр дагнан бичдэг сэтгүүлчид байсан. Харин боловсролын сэдвээр дагнан бичдэг сэтгүүлч байхгүй байна. Жишээлбэл, “Өнөөдөр” сонинд буй 35 нийтлэлийг 20 сэтгүүлч /давхацсан тоогоор/ бичжээ. Мөн боловсролын салбарын цаг үеийн асуудлаар хийж буй форум арга хэмжээний тухай мэдээг тогтмол сонинд оруулж байна. /Үүнд: Ихэнхдээ хэвлэлийн төлөөлөгч нарын бэлдэж өгсөн албаны мэдээ орно/. Сурвалжилга, ярилцлагын хувьд, түгээмэл сэдвээр хөөцөлдөж байна. Жишээлбэл, хичээл орох болохоор л цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ, барилгын асуудал гэх мэт. Асуудал дэвшүүлсэн шинжтэй нийтлэл маш

ховор байна. Гарчгийн хувьд, нэрлэн мэдээлэх гарчиг элбэг байна. Гарчгийг зорилгынх нь хувьд 6 ангилдаг. Гэтэл ганцхан ангиллыг нь түгээмэл ашиглаж байна. Жишээлбэл, “Зууны мэдээ” сонины 58 нийтлэлийн 37 нь нэрлэн мэдээлсэн гарчиг байна. Энэ нь сэтгүүлчийн ур чадварын түвшнийг тодорхой хэмжээнд харуулав. “Зууны мэдээ” мэдээ сониноос бусад сонинд боловсролын асуудлын талаар нийтэлдэг тогтмол булан байхгүй. Боловсролын салбарын асуудлыг бичихдээ ихэвчлэн хойд талын нүүрүүд дээр байршуулж байна. Жишээлбэл, “Өнөөдөр” сонины В1 нүүрт, “Зууны мэдээ” сонины 7-р нүүрт гэх мэт. Давтамжийн хувьд, 7 хоногт дунджаар 6-8 мэдээ, сурвалжилга, ярилцлага бичигдэж байна. Ихэвчлэн нэг өдөрт 3-4 мэдээ оруулсан тохиолдолд үүнд багтана.

Монголын шилдэг

мэдээллийн сайтуудын нэг болох IKON.mn нь боловсролын тэгш бус хүртээмжийн талаар маш олон удаа бичиж, шат дараалсан арга хэмжээ авах хүртэл нь цуврал хэлбэрээр уншигчдад хүргэж байна. Тухайлбал, хүүхэд хаана өсөж, төрж, амьдрахаасаа үл шалтгаалан боловсролыг тэгш хүртэх хэрэгтэй. Хотын захын сургуулийн хүүхдүүд, хотын төв орчим суралцаж буй хүүхдүүдийн хооронд боловсролын ялгаатай асуудлууд их байна гэж үзэн судалгаа, нотолгоотой

бичиж байна. Гэтэл өдөр тутмын сонины сэтгүүлчид асуудлыг энэ мэтээр гүнзгийрүүлэн авч, судлан удаа дараа цуврал хэлбэрээр бичихгүй байна. Тухайлбал, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” зэрэг сонины гурван сарын нийт 200 гаруй өдрийн дугаар шүүхэд боловсролын чухал асуудлыг олон удаа гаргаж тавьж, бичсэн

нийтлэл огт байгаагүй. Энэ нь боловсролын салбарын асуудалд маш хөнгөн, өнгөцхөн хандаж буй нь илт юм. Мөн өдөр тутмын сонинууд нь боловсролын салбарын асуудлыг төдийлөн чухалд тооцдоггүй нь тодорхой харагдаж байв. Жишээлбэл, дурын нэг боловсролын байгууллагын реклам, сурталчилгааг хүссэн хэлбэр хэмжээгээр нь нийтэлж өгч байна. Энэ нь нийгэмд ямар нөлөө үзүүлэхийг тооцсонгүй.

Боловсролын

сэдэвтэй нийт 137 нийтлэл байгаагийн тал нь буюу 66 нь цаг үеийн мэдээ байна. Харин 28 нь сурвалжилга, 37 нь ярилцлага, 6 нь тодруулга байна. Энэ нь маш чамлалттай тоо юм. Боловсролын салбарын асуудлаар бичсэн асуудлын нийтлэлүүд дотор мэдээллийн багтаамж сайтай, уншигчдын сонирхлыг татахуйц нийтлэл цөөн байлаа. Сонины редакцын бодлогоор боловсролын асуудлаар тухайн сэтгүүлчийг дагнан бэлдэх, сэтгүүлчийг тухайн салбараар нь мэргэшүүлэх,



Өдөр тутмын сонинууд нь боловсролын салбарын асуудлыг төдийлөн чухалд тооцдоггүй нь бидний судалгаанаас тодорхой харагдав. Боловсролын сэдэвтэй нийт 137 нийтлэл байгаагийн тал нь буюу 66 нь цаг үеийн мэдээ байна. Харин 28 нь сурвалжилга, 37 нь ярилцлага, 6 нь тодруулга байгаа нь маш чамлалттай тоо юм. Боловсролын салбарын асуудлаар бичсэн асуудлын нийтлэлүүд дотор мэдээллийн багтаамж сайтай, уншигчдын сонирхлыг татахуйц нийтлэл цөөн байлаа



нийтлэлийн чанар, хэмжээ зэрэгт анхаарах, боловсролын байгууллагын бэлдэж өгч буй албаны мэдээнээс аль болох татгалзах, боловсролын салбарын асуудлаар долоо хоногт 3-4 чанартай нийтлэл материал оруулах, цаг үеийн мэдээг орхих зэрэг юм.

Өдөр тутмын сонин дахь боловсролын сэдэвт мэдээллийн багтаамжийн тоон судалгаа нь Монголын ОНМХ-ийн ерөнхий дүр зургийг харуулах бөгөөд цаашид чанарын судалгаа, сэтгүүлчдэд зориулсан практик зөвлөмж, давтан сургалтын хэрэгцээ байгааг нотолж байна.

Эшлэл

¹ Зулькафиль М. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ. 2016. х.52.

²<https://unuudur.mn/%D2%AF%D0%BD%D0%B4%D1%81%D1%8D%D0%BD-%D0%B0%D0%BD%D0%B3%D0%B8%D0%BB%D0%B0%D0%BB/%D0%BD%D0%B8%D0%B9%D0%B3%D1%8D%D0%BC/%D0%B1%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B2%D1%81%D1%80%D0%BE%D0%BB/>

³<https://dnn.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D/%D0%B1%D1%83%D0%BB%D0%B0%D0%BD%D0%B3%D1%83%D1%83%D0%B4/%D1%88%D0%B8%D0%>

[BD%D0%B6%D0%BB%D1%8D%D1%85-%D1%83%D1%85%D0%B0%D0%B0%D0%BD-%D1%82%D0%B5%D1%85%D0%BD%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B3%D0%B8/](http://www.zms.mn/)
⁴ <http://www.zms.mn/>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль. М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
2. Норовсүрэн Л. 2006. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. 3-р боть. УБ.
3. Чойсамба Ч. 2006. Сонины мэдээ. УБ.
4. “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонины 2019 оны архив

Резюме

Авторы данной статьи затрагивают вопрос о тематике об образовании в ежедневных газетах Монголии. В статье уделяется внимание тому, что значение и количество журналистских публикаций в ежедневных газетах очень высоки, и дается анализ текущему состоянию тематике об образовании в трех лидирующих газетах Монголии. Также авторы показывают и анализируют статические подчеты площади и жанров, уделенных тематике об образовании.